



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/614

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөвт өртөг нь их, тухайн жилийн санхүүжилт нь бага, үр дүн муутай, цаашид хэрэгжих боломжгүй төсөл арга хэмжээнүүдийг судалж, худалдан авах ажиллагааг зогсоож аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийг хуралдуулж хууль тогтоомжийн дагуу шийдвэрийн төсөл боловсруулан хэрэгжилтийг ханган 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР